



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/132

Дэлгэрхаан сум

Орон нутгийн музейд амьтдын чихмэл хийхэд зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас төсөвлөсөн ажлын төлөвлөгөөний дагуу зарцуулж, байгалийн жам ёсны дагуу эндэж, хорогдсон амьтны арьсыг ашиглан (чоно-1, тарвага-1, үнэг-1 суурьтай) сумын байгалийн музейд танин мэдэхүйн зориулалтаар чихмэл хийлгэж байрлуулах ажлыг эхлүүлэхэд зардал гаргасугай.

2.Зэрлэг амьтны чихмэл хийх ажилд шаардлагатай 5,480,000 (таван сая дөрвөн зуун наян мянга) төгрөгнөөс эхний санхүүжилтээр 70 хувь буюу 3,836,000 (гурван сая найман зуун гучин зургаан мянга), ажил гүйцэтгэж ажлын хэсэгт хүлээлгэн тайлангаар баталгаажсаны дараа 30 хувь буюу 1,644,000 (нэг сая зургаан зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийг дансанд нь шилжүүлсүгэй.

3.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдэж буй чихмэл хийх ажлыг чанартай зохион байгуулж, ажлын тайланг, фото зургаар баталгаажуулж гаргаж ирүүлэхийг чихмэл урлаач (Д.Отгонсайхан)-д, хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (У.Ариунтуяа), байгаль хамгаалагч (Х.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 1.2-т заасны дагуу санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо) нарт даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2325010298